



# ДУАГ

ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

### ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Шилэн Данс

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛЭН ЗАХИРАГЧ | ЯАМ | АГЕНТЛАГ | ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙ НЭГЖ | ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР | АЖ АХУЙ НЭГЖ, ТӨРИЙН БҮС БҮЙГҮҮЛЭГ, ИРГЭН

Дундговь

Улаанбаатар	Баян-өлгий	Баянхонгор	Булган	Говь-алтай	Архангай
Говьсүмбэр	Дархан-уул	Дорноговь	Дорнод	<b>Дундговь</b>	Хэнтий
Завхан	Орхон	Өвөрхангай	Өмнөговь	Сүхбаатар	Хөвсгөл
Сэлэнгэ	Төв	Увс	Ховд		

Сайнцагаан сум  
Адаацаг сум  
Баянжаргалан сум  
Говь-Утгаал сум  
Гурвансайхан сум  
Дэлгэрхангай сум  
Дэлгэрцогт сум  
Дэрэн сум  
Луус сум

*Шилэн дансны тухай хуулийн зарим заалтын хэрэгжилт хангалтгүй байна*

2016 он

## АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгс	3
Дундговь аймгийн Аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4-5
Тэргүүлэх аудитор <b>Т.ОЮУНЧИМЭГ</b>	<b>БҮЛЭГ 1. Шилэн дансны тухай хуулийн 3.1.1-д заасан этгээдүүдээс 99 хувь нь шилэн дансны цахим хуудсанд хамрагдсан байна</b>	
	1.1 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн 99 хувь нь шилэн дансны цахим хуудсаа нээлгэсэн байна.	6
Аудитын менежер <b>Б.ГАНТУЯА</b>	1.2 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төрийн өмчит үйлдвэрийн газрын салбар байгууллагууд төв компанидаа нэгтгэгдэж мэдээлдэг байна	7
Ахлах шинжээч <b>Д.Ихбаяр</b>	1.3 Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани байхгүй байна.	7
Шинжээч <b>Д.Должинсүрэн</b>	1.4 Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагыг шилэн дансны нэгдсэн сайтад бүртгээгүй байна	7-8
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70593208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	<b>БҮЛЭГ 2. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг төсвийн байгууллагууд мэдээлж, ОНӨҮГ-ууд мэдээлэхгүй байна.</b>	
	2.1 Төрийн болон орон нутгийн өмчит төсвийн байгууллагууд тогтмол мэдээлэх мэдээг 93 хувьтай мэдээлсэн байна.	8-10
	2.2 Төрийн болон орон нутгийн өмчит төсвийн байгууллагууд долоо хоног бүр байршуулах мэдээг 96 хувьтай мэдээлсэн байна.	10-12
	2.4 Төрийн захиргааны байгууллага нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсанд байршуулах цэс байхгүй байна.	12
	<b>БҮЛЭГ 3. Шилэн дансны тухай хуулийн 7.1-т заасан зарим албан тушаалтан мэдээллийг иргэн олон нийтэд хүргэх үүргээ хангалтгүй гүйцэтгэж байна.</b>	
ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 214 тоот	3.1 Шилэн дансны тухай хуулийн 7.1-т заасан зарим албан тушаалтан шилэн дансны тухай хуульд заасан үүргээ хэрэгжүүлэхгүй байна.	13
	<b>БҮЛЭГ 4. Шилэн дансны тухай хуулийн 8.2-т этгээд шилэн дансны хяналтыг хэрэгжүүлээгүй байна</b>	
	4.1 Санхүүгийн хяналт, дотоод аудитын албыг 2016 онд шилэн дансны хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаагүй гэж үзлээ.	14

2016 оны 4 дүгээр сар	.	
	4.2 Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт 50 хувьтай байна.	14
	Дүгнэлт	15
	Зөвлөмж	
	Дээд шатны байгууллагад хүргэх санал	16
	Санал тайлбар	18-
	Тайлангийн хавсралтууд	27

### ТОВЧИЛСОН ҮГС

ҮАГ	Үндэсний аудитын газар
АТГ	Авилгатай тэмцэх газар
ААГ	Аймгийн аудитын газар
ААНТ	Аж ахуйн нэгжийн тооцоотой
АЗДТГ	Аймгийн Засаг даргын тамгын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НББ	Нягтлан бодох бүртгэл
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ГХБХБГ	Газрын харилцаа хот байгуулалтын газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨҮ	Орон нутгийн өмчит үйлдвэр
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
НЕҮ	Нийтийн ерөнхий үйлчилгээ
ЭМТ	Эрүүл мэндийн төв

## АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:** Аудитыг төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д заасан бүрэн эрхийн хүрээнд, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дах заалтыг үндэслэн, Дундговь аймгийн Аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хийлээ.

**Аудитын зорилт:** Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийсэн.

Үүнд:

- Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 3.1.3-т заасан байгууллагууд бүрэн хамрагдаж байгаа эсэх,
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 3.1.3-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлд заасан мэдээллийг мэдээлж байгаа эсэх,
- Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан этгээд хяналтыг хэрэгжүүлж байгаа эсэх,

**Аудитын хамарсан хүрээ:** Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан Дундговь аймгийн хэмжээнд хамрагдвал зохих нийт 189 байгууллагаас 165 байгууллага хамрагдсан. Үүнд:

Дундговь аймгийн 15 сум, аймгийн төвийн төсвийн шууд захирагчийн 140, төсвийн ерөнхийлөн захирагчийн 16, 3 сан, нийт 159 байгууллагын өөрийн цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулсан мэдээллийг анхан шатны баримт, 2016 оны батлагдсан төсвийн хуваарь, 1-3 дугаар сарын мэдээ, НББ-ийн журналтай тулган шалгасан.

Дундговь ус, Нийтлэг үйлчилгээ НББ-ийн мэдээллийг журналтай тулгаж, Дэрэн сумын Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээний төв, Дундговь аймгийн Цөм сүргийн үржлийн төв ОНӨҮГ, Дундговь Нисэх буудал, Автотээврийн үндэсний төв зэрэг ТӨҮГ-ын шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулсан эсэхийг шалгалалаа.

**Аудитын арга зүй, горим:** Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт шалгалтын стандарт түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, нийцлийн аудитын гарын авлагыг ашиглан, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох баримт цуглуулан дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу аудитын дараах горимыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Аудитад хамрагдсан байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тайлбар тодруулга авах, судалгаа хийх,
- Цуглуулсан мэдээ судалгаанд харьцуулалт, нөхцөл байдлын шинжилгээ хийх,
- Аудитад хамрагдсан байгууллагуудын нэгдсэн болон өөрийн цахим хуудас, мэдээллийн самбарт байрлуулсан мэдээллийг дансны хуулгын дүн, анхан шатны баримт, журналтай тулгах

**Аудитад ашигласан хууль, тогтоомж, шалгуур үзүүлэлт:** Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглаяа. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль,
- Төсвийн тухай хууль,

- Төрийн аудитын тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Засгийн газрын 2016 оны 01 сарын 11 ны өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан ”Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам,
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт.

**Аудитын хугацаа, агаар эгдүүд:** Аудитыг 2016 оны 03 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн 04 дүгээр сарын 30-ний өдөр хүртэл хугацаанд аудитын менежер Б.Гантуяа хянан удирдаж, нийцлийн аудитын багийн ахлах шинжээч Д.Ихбаяр, шинжээч Д.Должинсүрэн нар гүйцэтгэлээ.

**Аудитын дүн:** Аудитаар нийт 367.9 сая төгрөгийн / хавсралт 1/ зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар холбогдох албан тушаалтнуудад хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

### Ерөнхий мэдээлэл

Улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, нээлттэй, ил тод, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Шилэн дансны тухай хуулийг баталж, 2015 оны 01 дүгээр сарын 01-ээс мөрдөж эхэлсэн.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмыг 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 384 дүгээр тогтоолоор анх баталж шилэн дансны цахим сайтад мэдээллийг байршуулж эхэлсэн. 2016 оны эхээр шилэн дансны цахим сайт шинэчлэгдэн өмнөх журмыг хүчингүй болгож, 2016 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор журмыг шинэчлэн баталсан байна.

**БҮЛЭГ 1. Шилэн дансны тухай хуулийн 3.1.1-д заасан этгээдүүдээс 99 хувь нь шилэн дансны цахим хуудсанд хамрагдсан байна.**

**1.1 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн 99 хувь нь шилэн дансны цахим хуудсаа нээлгэсэн байна.**

Дундговь аймгийн хэмжээнд шинэчилсэн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1<sup>1</sup>-т заасны дагуу улсын төсөвт 27 байгууллага, түүний харьяа 3 сан, орон нутгийн төсөвт /тусгай зориулалтын шилжүүлгийн/ 130 байгууллага, ОНӨҮ-ийн 20 аж ахуйн тооцоотой газар нийт 180 байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудас бүртгэгдэхээс 178 байгууллагын цахим хуудас нээгдсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчит төсвийн байгууллагуудын 99 хувь нь шилэн дансны цахим хуудас нээлгэсэн байна.

### Шилэн дансны цахим хуудас нээлгэсэн судалгаа

Хүснэгт 1

Төсвийн Ерөнхийлөн захирагч	Байгууллагын төрөл	Байгууллагын тоо	Цахим хуудас нээгдсэн	Илүү + дутуу - цахим хуудас	Нээх ёстой
15 сум	ТШЗ	100	100		100
	ТЕЗ	15	15		15
Аймаг	ТШЗ	14	15	+1	14
	ТЕЗ	1	1		1
Яамдууд	ТШЗ	27	26	-1	26
	Сан	3	3		3
ОНӨҮГ	ААНТ	20	19	-1	20
<b>Нийт</b>		<b>180</b>	<b>179</b>	<b>-1</b>	<b>179</b>

Судалгаанаас үзэхэд улсын төсөвт 27 байгууллагаас Тагнуулын газар нь улсын нууцад хамрагдаж, бусад 26 байгууллагууд шилэн дансны цахим хуудсаа бүрэн нээлгэсэн байна.

Орон нутгийн өмчит төсвийн байгууллагаас Ахмадын хороо, Дундговь телевиз зэрэг байгууллагууд шилэн дансны цахим хуудсаа нээлгээгүй байна. Харин ГХБХБГ-ын цахим хуудсыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч болон Газрын харилцаа барилга хот байгуулалтын сайдын харьяанд давхардуулан нээсэн.

Энэ нь 2016 онд шилэн дансны нэгдсэн цахим сайт шинэчлэгдэж, байгууллагын админ хэрэглэгч төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах байгууллагын судалгааг гаргаж, бүрэн нээгээгүйтэй холбоотой бөгөөд, Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор батлагдсан шилэн

<sup>1</sup> 3.1.1 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд

дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 7.3<sup>2</sup>-т заасныг хэрэгжүүлээгүй.

### 1.2 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төрийн өмчит үйлдвэрийн газрын салбар байгууллагууд төв компанидаа нэгтгэгдэж мэдээлдэг байна.

Дундговь аймгийн хэмжээнд ТӨҮГ, ТӨХК-уудын 8 салбар байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас Зам тээврийн сайдын харьяа Нисэх буудал, Автотээврийн үндэсний төв гэсэн 2 салбар шилэн дансны цахим хуудсанд байгууллагын өөрийн цахим хуудастай, бусад салбар байгууллагууд шилэн дансны цахим хуудасгүй байна. Аудитын явцад энэ талаар тодруулахад харьяалах дээд шатны байгууллагад /Улаанбаатар хотод байрлах/ мэдээллээ нэгтгэн шилэн дансны цахим хуудсанд мэдээлдэг гэсэн хариуг ирүүлсэн.

#### Нэгдсэн цахим хуудастай салбаруудыг хүснэгтээр харуулбал:

хүснэгт 2

№	Харьяалах дээд шатны байгууллага	Байгууллагын нэр	Санхүүжилтын хэлбэр
1	Монголын цахилгаан холбоо ТӨХК	МЦХ ХК-ны Дундговь дах Холбооны газар	ААН тооцоотой
2	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК Дундговь газарт	ААН тооцоотой
3	Монгол шуудан ТӨХК	Дундговь аймгийн шуудангийн үйлчилгээний газар	ААН тооцоотой
4	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК Говийн бүсийн салбар	ААН тооцоотой
5	БЗӨБЦТС ТӨХК	БЗӨБЦТС ТӨҮК-ний Дундговь цахилгаан түгээх сүлжээ салбар	ААН тооцоотой
6	Монгол банк	Дундговь Монгол банк	ААН тооцоотой

Орон нутагт салбартай төрийн өмчит үйлдвэрийн газар болон хувьцаат компаниуд нь шилэн дансны цахим хуудсанд салбар байгууллага тус бүрээр эсвэл, нэгтгэж мэдээлэх эсэх талаар Шилэн дансны тухай хуулинд тодорхой заагаагүй байна. Энэ асуудлыг журмаар зохицуулан тодорхой болгох шаардлагатай байна.

### 1.3 Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани байхгүй байна.

Дундговь аймгийн хэмжээнд шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т “Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани” гэсэн заалтад хамаарах байгууллага байхгүй болно.

### 1.4 Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагыг шилэн дансны нэгдсэн сайтад бүртгээгүй байна.

<sup>2</sup> 7.3 байгууллагын админ хэрэглэгч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

.3.1 байгууллагын анкет болон байгууллагын админ хэрэглэгчийн хувийн мэдээллийг бөглөх

7.3.2 байгууллагын мэдээлэл оруулах хэрэглэгчид болон дотоод аудитын хэрэглэгч үүсгэх

7.3.3 байгууллагын данс нэмэх хүсэлтийг нэгдсэн админд илгээх



Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 9.3<sup>3</sup>-т заасны дагуу 2016 онд Аймгийн засаг дарга Дундговь аймгийн Чөлөөт ахмадын холбоо төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж эхний 2 сарын санхүүжилт олгосон боловч шилэн дансны цахим хуудсыг нээгээгүй байна.

Энэ нь шилэн дансны тухай хуулийн 3.1.5<sup>4</sup>, 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 1.3<sup>5</sup> гэсэн заалтыг зөрчиж байна. Иймд Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагатай гэрээ хийх эрх бүхий этгээд гэрээний нөхцөлд авсан санхүүжилтээ шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллэх талаар журамд тусгах шаардлагатай байна.

**БҮЛЭГ 2. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг төсвийн байгууллагууд мэдээлж, ОНӨҮГ-ууд мэдээлэхгүй байна.**

**2.1 Төрийн болон орон нутгийн өмчит төсвийн байгууллагууд тогтмол мэдээлэх мэдээг 93 хувьтай мэдээлсэн байна.**

Аудитаар 2016 оны 03 сарын 14-өөс 03 сарын 28-ийг хүртэл хөдөөгийн бүх /14/ сумдад очиж ажиллав. Томилолтоор ажиллах хугацаанд төсвийн шууд захирагч 85, төсвийн ерөнхийлөн захирагч 14, нийт 99 байгууллагын шилэн дансны мэдээллийг эхний 2 сарын байдлаар НББ-ийн анхан шатны баримт болон журнал, холбогдох мэдээ тайлантай тулган шалгалаа.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.1<sup>6</sup>, 3.1.2<sup>7</sup>-т заасан нийт 187 байгууллагаас 165 байгууллагын /15 сумын ЭЭС, Дундговь телевиз ОНӨҮГ, ТӨҮГ болон ТӨХК-ийн 6 салбар хасагдаад / шилэн дансны мэдээллийг шалгахад дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Дундговь аймгийн Цөм сүргийн үржлийн төв, Дундговь ус, Дэрэн сумын Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээний төв зэрэг ОНӨҮГ-ууд шилэн дансны нэгдсэн сайтад 2016 оны мэдээллээ байршуулаагүй. Аудитын явцад хугацаатай албан шаардлагыг Дундговь ус, Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээний төвд хүргүүлж, зөрчлийг арилгууллаа.
- Дундговь аймгийн Цөм сүргийн үржлийн төв ОНӨҮГ-ын эрх бүхий албан тушаалтантай аудитын явцад холбогдож чадсангүй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 1-р улирлын байдлаар сар бүр /тухай бүр/ мэдээлэх 11, жилд нэг удаа мэдээлэх 1 цэс нийт давхардсан тоогоор 34 цэсд мэдээлэл байршуулахаар байна.

<sup>3</sup> Энэ хуульд заасан төрийн болон нутгийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг ахмад настны төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсөл, арга хэмжээний зардлыг санхүүжүүлж болно.

<sup>4</sup> Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллага

<sup>5</sup> Байгууллага нь мэдээллийг тогтмол шинэчилж, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивт хадгалан, архивын мэдээллийн санд нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжийг хангасан байна

<sup>6</sup> 3.1.1 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд

<sup>7</sup> 3.1.2 төрийн өмчит үйлдвэрийн газар



Аудитын хамрах хугацаанд шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1<sup>8</sup>-д заасан мэдээллүүд нь байгууллагын бүтэц, зохион байгуулалтаас шалтгаалан шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулах цэсд нь ялгаатай байна.

Үүнийг харьцуулан хүснэгтээр харуулав. /Хүснэгт 3/

#### Тогтмол мэдээлэх цэсийн тоо

хүснэгт 3

Мэдээлэл тавих давтамж	ТШЗ /цэсийн тоо/	Сан /цэсийн тоо/	ОНӨҮГ /цэсийн тоо/	ТӨҮГ /цэсийн тоо/	ТЭЗ /цэсийн тоо/
Сар бүр	2	2	2	2	5
Сар бүр нийт	6	6	6	6	15
Жилд нэг удаа	1	1	1	1	1
Нэг удаа нийт	1	1	1	1	1
Бүгд	7	7	7	7	16

Шилэн дансны тухай хуулийн дагуу улс, орон нутгийн өмчит төсвийн байгууллага, ОНӨҮГ, ТӨҮГ –ууд тогтоосон хугацаанд байршуулах нийт 1,299 мэдээллээс 61.0 хувь буюу 793 мэдээллийг хугацаанд нь, 32.0 хувь буюу 416 мэдээллийг аудитын явцад нэмж, залруулан байршуулж нийт мэдээлэх мэдээний гүйцэтгэл 93 хувьтай байна. /Хүснэгт 4/ Үүнийг шилэн дансны цэсдээр нь авч үзвэл:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсанд мэдээлээгүй зөрчил нь аудитаар илэрсэн нийт 44 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл нийт байгууллагын 24 хувь буюу 40 байгууллага, шилэн дансны тухай хуулийн 6.1.1<sup>9</sup>-д заасны дагуу мэдээлээгүй байна. / хүснэгт 4/-г

Аудитын явцад 7 сумын 10 байгууллага нийт 329.3 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг мэдээлээгүй зөрчил илэрснийг хугацаатай албан шаардлага хүргүүлэн зөрчлийг арилгуулсан.

Хүснэгт 4

6.1 дэх мэдээллийг 165 байгууллага байршуулсан байдал						
журам	Заалтууд	Мэдээлэх тоо	Мэдээлсэн		Нийт мэдээлсэн	Мэдээлээгүй
			Аудит эхлэхэд	Аудитын явцад		
3.1.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв,	495	331	148	479	16

<sup>8</sup> 6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор

6.1.2.хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор;

6.1.6.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр.

<sup>9</sup> 6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор

	гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт					
3.1.4	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл	495	359	109	468	27
3.1.5	Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	48	26	22	48	0
3.1.8	Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл	48	35	13	48	0
3.1.14	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	165	16	109	125	40
3.1.15	Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл	48	26	15	41	7
	Нийт дүн	1299	793	416	1209	90

ОНӨҮГ-ууд 2016 оны 1, 2, 3 дугаар сарын төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэлийн мэдээ тайланг мэдээлээгүй байна.

ОНӨҮГ-уудаас шалтгааныг тодруулахад өмнөх оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийгдэн, дүгнэлт гарсны дараа буюу 4 сард ирэх оны байгууллагын зорилтот түвшингээ удирдах зөвлөлийн хурлаар баталуулдаг. Энэ 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 4.1.1<sup>10</sup>, 4.1.2<sup>11</sup>-заалттай зөрчилдөж байна.

Мөн аж ахуйн тооцоотой газрууд төсвийн байгууллагатай адил сар болгон гүйцэтгэлийн мэдээ тайлан гаргадаггүй, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21.4<sup>12</sup>, нягтлан бодох бүртгэлийн тухай 13.2.<sup>13</sup> зүйлийн дагуу зөвхөн улирал, хагас, бүтэн жилээр тайлан гаргадаг. Энэ нь шилэн дансны журмын 4т заасан заалттай зөрчилдөж байна

## 2.2 Төрийн болон орон нутгийн өмчит төсвийн байгууллагууд долоо хоног бүр байршуулах мэдээг 96 хувьтай мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд долоо хоногийн дотор байршуулах нийт 4,311 мэдээллээс 93 хувь буюу 4,002 мэдээллийг тогтсон хугацаанд, 3 хувь буюу 146 мэдээллийг аудитын явцад залруулан мэдээлж, мэдээлэл байршуулсан байдал 96 хувь байна.

<sup>10</sup> 4.1.1 мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх

<sup>11</sup> Төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын зорилтот түвшинг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, гүйцэтгэл хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 08-ны дотор энэ журмын 17 дугаар хавсралтаар цахимаар мэдээлнэ.

<sup>12</sup> Албан татвар төлөгч энэ хуулийн 21.3-т зааснаар хүргүүлсэн хуваарийн дагуу сар бүрийн 25-ны дотор албан татварыг урьдчилан төлж, татвар төлөлтийн улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд тушааж, албан татварын жилийн эцсийн тооцоо хийнэ.

<sup>13</sup> Аж ахуйн нэгж, байгууллага улирлын санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 20, жилийн санхүүгийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор харилцагч санхүүгийн байгууллагад тушаана.

- төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг долоо хоногийн дотор 64 байгууллага /192 тушаалаар 630.2 сая төгрөгийн шийдвэрийг хугацаанд/ мэдээлсэн байна. Харин 6 байгууллага 2.2 сая төгрөгийн тушаал шийдвэрийг мэдээлээгүй байсныг аудитын явцад залруулан нийт 632.4 сая төгрөгийн тушаал шийдвэрийн мэдээллийг байршуулсан.
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн мэдээллийг 146 байгууллагын 3,144.0 сая төгрөгийн худалдан авалтыг мэдээлж, 6 байгууллагын 128.0 сая төгрөгийн худалдан авалтыг мэдээлээгүй байсныг аудитын явцад залруулсан.

Мэдээлэл байршуулсан байдлыг хүснэгтээр харуулбал:

6.4 мэдээллийг 165 байгууллагын мэдээлэл байршуулсан байдал						
хууль	Заалтууд	Мэдээлэх тоо	Мэдээлсэн		Нийт мэдээлсэн	Мэдээлээгүй
			Хугацаандаа	Хугацаа хоцорсон		
6.4.1	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	495	470	2	472	23
6.4.2	Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт	495	476	5	481	14
6.4.3	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл	495	450	2	452	43
6.4.4	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	495	480	1	481	14
6.4.5	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ	447	442	2	444	3
6.4.6	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	495	478	0	478	17
6.4.7	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	447	307	128	435	12
6.4.8	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	495	471	4	475	20
6.4.9	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл	447	428	0	428	19
	Нийт дүн	4311	4002	144	4146	165

- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг 29 байгууллагын 122 гүйлгээгээр гарсан 6,386.05 сая төгрөгийн зарлагын гүйлгээг шилэн дансны цахим хуудсаар мэдээлсэн, 4 байгууллагын 6 гүйлгээгээр гарсан 104.5 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байсныг нөхөн мэдээлсэн.
- Таван сая төгрөгөөс дээш гарч байгаа зардлын гүйлгээний ихэнхийг түлш халаалтын зардал болон сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн гүйлгээ эзэлж байна.

Харин 6 байгууллагын 33 гүйлгээгээр 5,842.0 сая төгрөгийн орлого мэдээлсний ихэнх буюу 72 хувийг халамжийн сангийн орлогууд эзэлж байна.

- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг 149 байгууллага 447 цэсээр мэдээлэхээс 97.00 хувь буюу 435 цэсээр мэдээлсэн байна. Үүний 29.00 хувь буюу 128 нь хугацаа хоцорч мэдээлэгдсэн нь байгууллагууд оны эхнээс батлагдсан бүтэц орон тооны талаар “өөрчлөлт ороогүй” гэж мэдээлснийг аудитын явцад шилэн дансны тухай хуулийн 4<sup>14</sup> дүгээр зүйлийн дагуу оны эхнээс маягтын дагуу нөхөн засуулсантай холбоотой.
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг 165 байгууллага “БАЙХГҮЙ” гэж мэдээлсэн байна.
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт зэрэг цэсүүдийг ихэнх байгууллага буюу 92% нь “ӨӨРЧЛӨЛТ ОРООГҮЙ” буюу “БАЙХГҮЙ” гэж мэдээлсэн байна.

Аудитын явцад ажигласнаар хөдөө орон нутгийн ИТХ, Соёлын төв, Цэцэрлэг зэрэг төсөв багатай байгууллагууд сарын гүйцэтгэлийн мэдээ, орон тооны өөрчлөлт, төсөв өмч хөрөнгө захиран зарцуулах гэсэн 2-3 цэст л мэдээлэл байршуулахаас бусад цэсэд мэдээлэл оруулах шаардлага байхгүй байна.

### **2.3 Шилэн дансны тухай хуулийн 6.5-д /санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага/ гэсэн заалт аймагт хамааралгүй.**

### **2.4 Төрийн захиргааны байгууллага нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсанд байршуулах цэс байхгүй байна.**

2016 онд шинэчлэгдсэн шилэн дансны нэгдсэн сайтад Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс үйл ажиллагааны болон нийгмийн даатгалын сан гэсэн 2 цахим хуудастай байна. Шилэн дансны тухай хуулийн 6.7-т / Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон бусад төрийн захиргааны байгууллага нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсанд байрлуулан тухай бүр шинэчилж мэдээлнэ./ гэж заасан боловч байршуулах цэс нээгдээгүй байна.

<sup>14</sup> 4.1.1 мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх

4.1.2 мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх

4.1.3 тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх

**БҮЛЭГ 3.** Шилэн дансны тухай хуулийн 7.1-т заасан зарим албан тушаалтан мэдээллийг иргэн олон нийтэд хүргэх үүргээ хангалтгүй гүйцэтгэж байна.

### **3.1 Шилэн дансны тухай хуулийн 7.1-т заасан зарим албан тушаалтан шилэн дансны тухай хуульд заасан үүргээ хэрэгжүүлэхгүй байна.**

Шилэн дансны шинэчлэгдсэн цахим хуудас нь өмнөх цахим хуудастай харьцуулбал байгууллага бүр байгууллагын админы эрхтэй болж ажлын чиг үүргээс нь хамааран шилэн дансны тухай хуулийн 7.1<sup>15</sup>-т заасан албан тушаалтан тус бүрээр мэдээлэл оруулах эрхийг /29 дүгээр тогтоолоор батлагдсан/ журмаар зохицуулж өгсөн. Үүний дагуу төсвийн байгууллагын дарга, нягтлан бодогч, санхүүгийн мэргэжилтэн нарт ажил үүргийнх нь дагуу шилэн дансны мэдээлэл оруулах эрхийг хуваарилан өгсөн байна.

Аудитаар сумдын 1-2 сарын шилэн дансны мэдээлэл байршуулсан байдалд судалгаа хийж үзэхэд / онооны системээр үнэн зөв оруулсан бол 1 оноо, хугацаа хоцорсон бол 0.5 оноо, огт мэдээлээгүй бол 0 оноо/ Дэлгэрхангай-67 хувь, Цагаандэлгэр-66 хувь, Баянжаргалан-76 хувь, Сайхановоо-78 хувь байгаа нь бусад сумдаас харьцангуй бага хувьтай байна./ График1/

Үүнийг тодруулахад төсвийн байгууллагын нягтлан бодогч нар мэдээллээ бүрэн оруулсан боловч эрх нээлгэсэн дарга нар шилэн дансны цахим хуудсанд оруулах мэдээллээ оруулаагүйгээс шалтгаалжээ. Энэ нь байгууллагын дарга, эрхлэгч нар шилэн дансны тухай хуулийг бүрэн уншиж судлаагүй, шилэн дансанд мэдээлэл байршуулахыг зөвхөн нягтлан бодогчийн үүрэг гэж үздэгтэй холбоотой байна.

Мөн мэдээлэл оруулах хэрэглэгчийн чиг үүрэгт шилэн дансанд байршуулах мэдээллээ цахим хуудсанд оруулахаас өмнө үнэн зөв, бүрэн эсэхэд хяналт тавих үүрэгтэй. Гэтэл зарим байгууллагын дарга, эрхлэгч нар бичиг хэрэг, болон бусад мэргэжилтэнгүүдэд шилэн дансны мэдээлэлд нэвтрэх эрхээ шилжүүлэн өгсөн, эрх шилжүүлсэн тохиолдолд шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийг шалгаж үзэхгүй, хянахгүй байна. Иймд шилэн дансны тухай хуулийн 7.2<sup>16</sup>-т заасныг анхаарч ажиллах хэрэгтэй.

Дээрх сумдуудын удирдлагад зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

График1, график 2 –оос харахад Сайхан-Овоо сум аудитаар өгсөн албан шаардлагыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна. Судалгаанаас харахад /хавсралт 2/ ТЕЗ-ын шилэн дансны цахим хуудсны үзүүлэлт хамгийн бага хувьтай байгаа нь мэдээлэл оруулах хэрэглэгч нар мэдээллээ цаг хугацаанд нь оруулсан эсэхэд тавих хяналт хангалтгүйтэй холбоотой байна.

<sup>15</sup> 7.1.1 төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан

7.1.2 энэ хуулийн 7.1.1-д заасан эрх бүхий албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь хөндлөнгөөс нөлөөлсөн албан тушаалтан

7.1.3 тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан

<sup>16</sup> 7.2 энэ хуулийн 7.1-д заасан эрх бүхий албан тушаалтан мэдээлэх үүргээ бусдад шилжүүлсэн нь хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй

Сумдын 2016 оны эхний 2 болон 3 сараар мэдээлэл оруулсан байдлыг харьцуулбал:

график 1




график 2



**БҮЛЭГ 4.** Шилэн дансны тухай хуулийн 8.2-т заасан этгээд шилэн дансны хяналтыг хэрэгжүүлээгүй байна

#### 4.1 Санхүүгийн хяналт, дотоод аудитын албыг 2016 онд шилэн дансны хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаагүй гэж үзлээ.

